



2025-2027 ОНЫ ХАМТЫН ГЭРЭЭНИЙ 2025 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ДҮГНЭЛТ

“Оюу Толгой” ХХК-ийн Уул уурхайн ажилтны ҮЭ-ийн Хороо, “Оюу Толгойн” Орон нутгийн ажилчдын ҮЭ-ийн Хороо, “Оюу Толгой” ХХК хамтран “Хамтын гэрээ”-ний хэрэгжилтийг дүгнэх хурлыг 2025 оны 12 сарын 4-ний өдөр зохион байгууллаа.

Ажил олгогч талаас Санхүү эрхэлсэн захирал Б.Дуламсүрэн, Үйл ажиллагаа эрхэлсэн захирал орлон гүйцэтгэгч, Ил уурхайн үйл ажиллагаа хариуцсан Ерөнхий менежер Т.Отгонбаяр, Хүний нөөцийн ерөнхий менежер Лори Ирвин, Хүний нөөцийн Хөдөлмөрийн харилцааны баг, ҮЭ-ийн Хороодын дарга тэргүүлэгчдийн төлөөлөл оролцов.



Хамтарсан хуралдаанаар ‘Хамтын гэрээ’ нийт 10 бүлэг, 85 заалттай болохыг танилцуулав. Үүнээс зорилго болон нийтлэг үндэслэлд хамаарах 9 заалтыг хэрэгжилтийн үнэлгээнд хамруулаагүй бөгөөд үлдсэн 76 заалтад 7 дэд заалт нэмэгдсэнээр нийт 83 заалтаар тус бүрээр нь хэлэлцэн хэрэгжилтийг дүгнэв. 2025 онд ‘Хамтын гэрээ’-ний хэрэгжилт 97.6 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлэгдэж, зарим заалтын хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр тохиролцлоо.



2025-2027 оны хамтын гэрээний дүгнэлт

Хамтын гэрээний хэрэгжилтийн дүгнэлт-2025 оны 12 сарын 4-ний өдөр

Хамтын гэрээний заалтын агуулга	ХГ-ний заалт	Хэрэгжсэн байдал (2025 оны 10 сарын байдлаар)	Хэрэгжилтийн ХУВЬ
III-Бүлэг-Хөдөлмөр, эрхлэлт ажлын байрны баталгаа			
Хамтын гэрээний заалт хууль тогтоомжид зааснаас дордоогүй байх	3.1	Дордуулсан заалт байхгүй	100%
ҮАМАТ-ын дагуу ажлын байрны тодорхойлолтуудыг нягтлах	3.2	Уг ажлыг гүйцэтгэх байгууллагыг сонгох тендерийн сонгон шалгаруулалтын ажил дууссан ба шалгарсан компанид ажлаа эхлүүлэхэд шаардлагатай суурь мэдээллүүдийг бэлдэж байгаа.	100%
Орон тоо цөөрсөн хасагдсан, эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй ажилтныг өөр тохирох ажлын байранд шилжүүлэх	3.3	Эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй 4 ажилтныг өөр ажлын байранд шилжүүлсэн. Гүний уурхайн орон тоо цөөрсөн хасагдсаны улмаас 3-р улирлын байдлаар 16 ажилтныг өөр ажилд шилжүүлсэн.	100%
Өөр тохирох ажлын байранд шилжүүлэх боломжгүй бол тэтгэмж олгох	3.4	11 ажилтанд тус тэтгэмжийг олгосон ба энэхүү тоо нь 9 сарын 30-ны өдрийн байдлаарх буюу 3-р улирлын байдлаарх тоо.	100%
Ердийн өвчний улмаас ажилдаа тэнцэхгүй болж ажлаас гарах тохиолдолд 12 сарын тэтгэмж олгох	3.5	4 ажилтанд тус тэтгэмжийг олгосон.	100%
Мэргэжил, ур чадварын хувьд ажилдаа тэнцэхгүй болж ажлаас гарах тохиолдолд тэтгэмж олгох	3.6	Ийм тохиолдол гараагүй.	100%
Бөөнөөр халах тохиолдолд 45-с доошгүй хоногийн өмнө ҮЭХнд мэдэгдэх	3.7	Ийм тохиолдол гараагүй	100%

IV Бүлэг-Цалин хөлс

Үндсэн цалингийн нэмэгдэл	4.1	2025 оны 3 сарын 1-нээс үндсэн цалинг 200 ам.доллараар нэмсэн	100%
Цалингийн судалгаа	4.2	Тус судалгааг хийж, ҮЭХороодод 2025 оны 1 дүгээр улирлын хурлаар танилцуулсан	100%
Дундаж цалин хөлсний бүрэлдхүүн болон дундаж цалин хөлсний томьёо	4.3	Тухайн бүрэлдэхүүн болон томьёоны дагуу хэрэгжүүлж байгаа.	100%
Илүү цагийн нэмэгдэл хөлс	4.4 (1)	3775/41529 ажилтанд тус нэмэгдэл хөлсийг олгосон	100%
Шөнийн ээлжийн нэмэгдэл хөлс	4.4 (2)	1914/21061 ажилтанд тус нэмэгдэл хөлсийг олгосон	100%
Нийтээр амрах баярын өдрийн нэмэгдэл хөлс	4.4 (3)	1086/11948 ажилтанд тус нэмэгдэл хөлсийг олгосон	100%
Уртын ээлжийн нэмэгдэл	4.5 (1)	3822 ажилтанд тус нэмэгдлийг олгосон	100%
Хоол унааны хөнгөлөлт	4.5 (2)	578 ажилтанд тус хөнгөлөлтийг олгосон	100%
Уртын ээлж болон оффист ажиллах бол нэмэгдэл хөнгөлөлтийг ажиллах хуваарийн дагуу тооцон олгох	4.5(3)	294 ажилтанд тус хөнгөлөлтийг олгосон	100%
Дуудлагын цагийн олговор	4.6	138/1526 ажилтанд тус олговрыг олгосон	100%
Сул зогсолтын олговор	4.7	59 ажилтанд тус олговрыг олгосон	100%
Өндөр хариуцлага бүхий ажилтны үүргийг хавсран гүйцэтгэсний нэмэгдэл	4.8 (1)	73 ажилтанд тус нэмэгдлийг олгосон	100%
Ижил түвшний ажил хавсран гүйцэтгэх	4.8 (2)	85 ажилтанд тус нэмэгдлийг олгосон	100%
Өндөр хариуцлага бүхий ажилтны үүргийг орлон гүйцэтгэсний нэмэгдэл	4.8 (3)	241 ажилтанд тус нэмэгдэл хөлсийг олгосон	100%
Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн нэмэгдэл	4.9	2840/31250 ажилтанд тус нэмэгдэл хөлсийг олгосон.	100%

Засвар үйлчилгээний зогсолтгүй үйл ажиллагааны нэмэгдэл	4.10	2736 ажилтанд тус нэмэгдлийг олгосон	100%
Зогсолтгүй үйл ажиллагааны нэмэгдэл	4.10	538 ажилтанд тус нэмэгдлийг олгосон	100%
Гүйцэтгэлийн үнэлгээг 4-р улиралд хийнэ, үнэлэгээний үр дүн жилийн урамшуулалтай холбогдоно.	4.11	Ажилтны гүйцэтгэлийн үнэлгээг 10 сарын 27-ноос 12 сарын 22-ны хооронд хийхээр төлөвлөгдсөн, хэрэгжилт хуваарийн дагуу хэвийн үргэлжиж байна.	50%
Жилийн урамшуулал олгох, урамшуулал тооцох аргачлалыг сайжруулах ба ҮЭХ-ны саналыг тусгана.	4.12	2026 оны 1 сарын дундуур 2025 оны урамшуулал тооцох процесс эхлэх бөгөөд энэ үед холбогдох сайжруулалтыг хийхээр судалж байна. 2026 оны 2 сард хэрэгжүүлж дуусахаар төлөвлөж байна.	Төлөвлөгдсөн
Удаан хугацаанд ажилласан жилийн урамшуулал	4.13	Өмнө нь жилд 2 удаа олгогддог байсныг, ажилласан жилийн ой тохойж буй сар бүрд нь олгож эхлэсэн. Нийт 205 ажилтанд олгосон.	100%
Цалин олгохдоо бодох аргачлал, цалин хөлсний бүрэлдэхүүн, цалингийн бодолтыг энгийн ойлгомжтой, тодорхой, бичгээр эсхүл цахимаар мэдэгдэнэ	4.14	ЦБЦБСС ажлын хэсгийн хүрээнд цалингийн дэлгэрэнгүй дээр нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг тооцож байгаа томъёолол, тайлбарыг нэмж 2025-7-25-аас ашиглаж эхлэсэн. Ажилтнууд өөрсдийн цалингийн дэлгэрэнгүйг авах имэйл хаягаа цаг бүртгэлийн системээр дамжуулан бүртгүүлэх хэрэгтэй. Цалингийн тооцоолуурыг хялбаршуулан ОТ портал дээр байршуулсан.	100%
Цаг бүртгэл, цалин бодолтын системийн сайжруулалт, урт хугацааны чөлөөтэй үеийн цалин хөлсний бодолтыг сайжруулах	4.15	Цаг бүртгэл, цалин бодолтын системийн сайжруулалтын ажлын хэсэг 2024 оны 12 сараас ажиллаж эхэлсэн бөгөөд хийгдсэн сайжруулалт болон холбогдох мэдээлэл энэхүү хурал дээр танилцуулагдана.	100%
Нийт ажилтны, газар, хэлтс-н олонхын цалин бууруулахаас ажлын 15 хоног-н өмнө ҮЭХ-нд мэдэгдэж, өөрчлөх	4.16	Ийм тохиолдол гараагүй	

V Бүлэг-Ажилтны нийгмийн хамгаалал, хөнгөлөлт			
Тэтгэвэр хуримтлалын сан	5.1	Компани 4538 ажилтны үндсэн цалингийн 3%-тай тэнцэх хуримтлалыг ажилтны дансанд шилжүүлж байна	100%
Тэтгэвэр хуримтлалын талаарх Хууль тогтоомж өөрчлөгдвөл хамтарсан ажлын хэсэг байгуулж, зохих өөрчлөлтийг оруулна	5.2	Хууль тогтоомжид ямар нэг өөрчлөлт ороогүй байна.	100%
Эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалд нийт ажилтнуудаас гадна Ажилтны гэр бүлийн 2 гишүүнийг даатгуулна	5.3	2025 -11-25-ны байдлаар нийт ажилтан болон тэдгээрийн гэр бүлийн гишүүн болох нийт 14,256 хүнийг Мандал даатгалд хамруулж байна.	100%
Ажилтнуудын хүүхдүүдэд зориулан дотоодын их дээд сургуульд суралцах тэтгэлгийг жил бүр 30 оюутанд олгоно	5.4	2024-2025; 2025-2026 оны хичээлийн жилд тус бүр 30 оюутанд тэтгэлэг олгосон. Тэтгэлэгт: 1. Сургалтын төлбөр 100% 2. Дотуур байрны зардал 3.Сар бүрийн амжиргааны зардал 4. Залуусын хөгжлийн хөтөлбөр	100%
Гуравдагч байгууллагуудын хөнгөлөлтийн хөтөлбөрүүд нь зөвхөн ҮЭХ-ны гишүүдэд хамаарна.	5.5	ҮЭХороод хэрэгжүүлж байна. ОТ үндсэн болон туслан гүйцэтгэгч бүх ажилтнуудыг хамруулж бгаа	75%
Төрийн болон салбарын шагнал	5.6	122 ажилтанд мөнгөн шагнал олгосон.	100%
Гашуудлын тэтгэмж (5 сая)	5.8	Нийт 161 ажилтанд 805,000,000 төгрөгийн тэтгэмж олгосон.	100%
Нас барсан ажилтанд олгох тэтгэмж (12 сарын үндсэн+ 10 сая+3 сарын дундаж)	5.7 & 5.8	2 ажилтны ар гэрт 239,270,230 төгрөг тэтгэмжийг олгосон	100%
Үндсэн асран хамгаалагчийн /ээжийн/ чөлөө	5.9	99 ажилтанд чөлөөний олговрыг олгосон	100%
Шинээр хүүхэдтэй болсон эцэгт олгох чөлөө	5.1	310 ажилтанд чөлөөний олговрыг олгосон	100%
Ажил олгогч нь эх үрсийн баярыг тохиолдуулан ажилтнуудынхаа 16 хүртэлх насны хүүхэд бүрт бэлэг олгоно	5.11	16 болон түүнээс доош насны 9200 гаруй хүүхдэд бэлэг өгсөн	100%
Тэтгэвэрт гарсан ажилтанд олгох тэтгэмж	5.12	5 ажилтанд 305,862,783 төгрөгийн тэтгэмж олгосон	100%

VI Бүлэг-ажил амралтын хуваарь

14 хоног, амрах 14 хоног байх уртын ээлжийн хуваарийг хэрэгжүүлнэ	6.1	3638 Тус хуваариар ажиллаж байна.	100%
14/14-г багасгах тохиолдолд ажиллах, амрах хугацаа нь тэнцүү байх хуваарийг Ажилтантай тохиролцсоны үндсэн дээр хэрэгжүүлнэ	6.2	284 Ажилтан 7/7, 3,5/3,5 хуваариар ажиллаж байна.	100%
Хуваарь, ээлжийг өөрчлөх бол 7 хоногийн өмнө мэдэгдэх	6.3	Хэрэгжүүлж байгаа.	100%
6.1, 6.2-т зааснаас өөр ажил, амралтын хуваарийг тохиролцож хэрэгжүүлж болно.	6.4	Хэрэгжүүлж байгаа.	100%
Байгалийн гэнэтийн хүчин зүйлсийн улмаас үүссэн нөхцөл байдлыг харгалзан 3 хүртэлх хоногийн үндсэн цалинтай Онцгой шалтгааны хувийн чөлөөг олгоно.	6.5	Одоогоор тус чөлөөг авсан ажилтан байхгүй байна.	100%
Олон улсын урлаг, спортын арга хэмжээнд 5 хүртэлх хоногийн олговортой чөлөө олгох	6.6	44 ажилтанд тус чөлөөг олгосон.	100%
Үндэсний хэмжээний спортын тэмцээнд 5 хүртэлх, салбарын тэмцээнд 3 хүртэлх өдрийн олговортой чөлөө олгоно	6.7	44 ажилтанд тус чөлөөг олгосон.	100%

VII Бүлэг-Мэргэжил олгох, дээшлүүлэх талаар

Талууд хэрэгцээт сургалтыг хамтран зохион байгуулна.	7.1	Одоогоор аль нэг талаас хамтран зохион байгуулах сургалт санал болгоогүй.	100%
Мэргэжлийн зэрэг олгох, зэрэг ахиулах сургалтын зардлыг Ажил олгогч хариуцна	7.2	2025 оны 10 сарын байдлаар нийт 304 ажилтан мэргэжил олгох & мэргэжлийн зэрэг ахиулах сургалтад хамрагдсан байна	100%
		•249 техникийн ажилтнууд ХБНГУ-ын техникийн мэргэжил олгох Cert IV	
		•18 ажилтан дугуйн аюулгүй ажиллагааг хангах ОУ-ын мэргэшсэн сургалт	
		•14 ажилтан ШУТИС-ын уул уурхай, тоног төхөөрөмжийн бакалавр	
	7.3	•23 техник/ажилтан Баяж/үйлдвэрийн фолтазын мэргэшил олгох сургалт	100%
		ЭМААБО сургалтуудын хүрээнд 2025 оны III улирал дуустал нийт 639,117 хүн-цаг сургалт зохион байгуулагдсан. 2025 оны 10 сар дуустал Аюулгүй ажиллагааны сургалтын баг нийт 81 төрлийн ЭМААБО сургалт зохион байгуулж, 67,803 давхардсан тооны оролцогч хамрагдсан. Харин бусад Түншлэгч багууд (Даян, Хишиг-Арвин тийс) нийт 52 төрлийн сургалт зохион байгуулж, 13,079 давхардсан тооны оролцогч хамрагдсан байна.	
Өөрийгөө хөгжүүлэх санаачлага гаргасан ажилтанд Компанийн Авъяас, ур чадварыг хөгжүүлэх стратегийн хүрээнд бизнесийн хэрэгцээ шаардлагыг харгалзан, ажилтны ажил үүрэг, хувийн хөгжлийн төлөвлөгөөтэй нийцүүлэн дэмжлэг үзүүлнэ.	7.4	Ажилтан бүр хөгжлийн зорилгоо оны эхэнд гүйцэтгэлийн зорилготой хамт дэвшүүлэн хэрэгжүүлж ажиллаж байгаа. Ажилтан бүрийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн жилийн эцсийн гүйцэтгэлийн уулзалтаар ахлахтайгаа ярилцдаг. Гүйцэтгэл болон хөгжлийн төлөвлөгөөтэй хамааралтай бүх ажилтнуудад зориулсан цахим сургалт боловсруулж хүргэсэн. Мөн танилцуулах видео гаргасан.	100%

Ажил олгогч нь Ажилтнуудын манлайлал болон удирдах ур чадварыг сайжруулж, хөгжүүлэх зорилгоор манлайллын хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	7.5	Ахлах ажилтнуудад зориулсан хөгжлийн хөтөлбөр шинээр хэрэгжиж эхэлсэн, нийт 20 ахлах ажилтан эхний сургалтанд хамрагдсан. Ирэх онд 120 ахлах ажилтныг хамруулах төлөвлөгөөтэй. Аюулгүй ажиллагааны ярилцлага сургалтанд ОТ-60, гэрээт компаний ажилчид 120 гаруй хамрагдсан.	100%
Залгамж халаа бэлдэх төлөвлөгөө боловсруулна.	7.6	2025 онд 250 ажлын байрны залгамж халааг тодорхойлж, 835 ажилтан 1-5 жилийн хугацаанд эдгээр ажлын байранд ажиллах боломжтой гэж тодорхойлсон.	100%
Ажиллаж бхдаа сургалтанд хамрагдвал цалин хөлсийг бүтэн олгоно. Амарч байхдаа хамрагдвал нөхөн амарна, боломжгүй бол үндсэн цалинг олгоно.	7.7	Нийт 1866 хүнд 1,234,167,292 төгрөг (энэ нийт дүнд сургалт болон эмчийн үзлэгт хамрагдсан нийлбэрээрээ олгогдсон дүн харагдаж байгаа, ялгаж татах боломжгүй учраас нийлбэрээр нь татсан дүн болно)	100%
Талууд ажлын хэсэг байгуулан оператор болон техник мэргэжлийн ажлын байрны ур чадварын ялгааг нягтлах ажлыг хэрэгжүүлнэ	7.8	Талууд ажлын хэсэг байгуулан, 11 сарын 20-нд эхний хурлаа хийсэн. Талууд одоогоор ажлын хэсгийн удирдамж дээрээ тохиролцохоор ажиллаж байгаа ба ОТОНАҮЭХ-ээс саналыг хүлээж байгаа. Дараагийн хурлыг 12 сарын сүүлээр хийх товтой байна.	100%

VIII Бүлэг-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

Аюулгүй ажлын байраар ханган, ЭМАА-нд дэлхийн шилдэг тэргүүний практик туршлагыг нэвтрүүлэх, тогтмол шинэчлэн сайжруулах зарчмыг баримтална	8.1	Үргэлжилж байгаа. Компанийн ЭМАА-ны өнөөгийн нөхцөл байдал, дэлхийн бусад уурхайд хэрэгждэг тэргүүн туршлагуудыг хаанаас ямар туршлага авах боломжтой талаар хэдхэн удаагийн аудит шалгалт, үнэлгээ хийлгэж туршлага солилцсон. Үүнд: Гүний, Ил уурхай, Баяжуулах үйлдвэрт гардаг тоостой холбоотой хөндлөнгийн аудит хийлгэсэн. Гүний, Ил уурхайн Онц аюултай эрсдлүүдийн хяналт, удирлагын тогтолцоо дээр РТ-ийн мэргэжилтэй инженерүүдийг уурхайд урьж эрсдэл бүр дээр ярилцаж шилдэг туршлагуудыг хуваалцаж нарийвчилсан төлөвлөгөө гаргасан. ЭМАА-ны Төлөвлөлийн 3 удаагийн үнэлгээ/аудит хөндлөнгөөс хийлгэж дэлхийн шилдэг тэргүүний туршлагыг нэвтрүүлэх, тогтмол шинэчлэн сайжруулах зарчмыг баримталж 2026 оны ЭМАА-ны стратеги төлөвлөгөөнд тусган ажиллаж бна.	50%
ХГ-ний хэрэгжилтийг хангах, ХАБЭА асуудлыг цаг алдалгүй ярилцах, шийдвэрлэх тогтолцоог бий болгохоор хамтран ажиллана. ХО санамж бичиг батална	8.2	Харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулан нийт 56 хурал хийн 154 асуудалд хариу өгсөн байна.	75%
Эрсдэлийн түвшин их ажлын байр дах ажилтнуудыг амь нас, эрүүл мэндийн даатгалд даатгуулна	8.3	2025 оны 11 сарын 25-ны байдлаар тэсэлгээ болон тэсэрч дэлбэрэх бодистой ажилладаг нийт 231 ажилтныг амь насны даатгалд даатгуулсан байна.	100%

Эрсдэлийн түвшин их ажлын байр дах ажилтнуудыг амь нас, эрүүл мэндийн даатгалд даатгуулна	8.3	2025 оны 11 сарын 25-ны байдлаар тэсэлгээ болон тэсэрч дэлбэрэх бодистой ажилладаг нийт 231 ажилтныг амь насны даатгалд даатгуулсан байна.	100%
1.Ажил эхлэхээс өмнөх болон урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах.	8.4	1.Ажилд орохын өмнөх болон хугацаат үзлэгт нийт ажилтнуудыг ажлын онцлог, ижил өртөлтийн бүлэгийн байдлаар 1 жил эсвэл 2 жил тутам хамруулж байна.	50%
2.Өндөр чанартай XXXX-ээр хангана.		2. XXX-ийн журмын шаардлагуудын дагуу XX хэрэгслүүд нь ОУ-ын стандартад нийцсэн эсэхийг XXXХороогоор хянаж зохих удирдлагаар батлуулан ОТ сайтад ашиглах зөвшөөрөл өгч ажилладаг. 3. Гүний уурхай болон Ил уурхайд нийтдээ 20 гаруй ЭМААны хороотой. Сар бүр менежерүүдийн хурлаар тухайн хэсэгт ЭМААны асуудал байвал дэвшүүлээд явж байгаа тул ЭМААхороог давхар хуралдуулах шаардлагагүй гэж тохирсон.	
3.ЭМАА-ны хороог байгуулж, ажиллана.		4. ЭМААБО-ны холбоотой асуудлаар 80 гаруй санал хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэсэн. Ихэнх нь Хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилт мониторинг хийлгүүлэх хүсэлт байсан байна.	
4.АА-тай холбоотой асуудлаар Ажилтан, гэрээт-ийн ажилтнаас гаргасан санал хүсэлтийг шийдвэрлэнэ.			
ХН үнэлгээг хийлгэнэ. Үнэлгээ хийх үйл явцад ХАХэсэг байгуулж, ажлын хэсэгт ҮЭХг оролцуулж, хяналт тавина. Холбогдох тайлан мэдээллийг тогтмол өгөх	8.5	2024 оны үнэлгээ дахин баталгаажуулахаар 2026 онд үнэлгээ хийлгэхээр 2025 онд тендер зарлаж үнэлгээ хийх байгууллагыг сонгосон. Үнэлгээ эхэлмэгц ажлын хэсгээ хуралдуулж, ҮЭХ-г оролцуулж эхэлнэ.	100%
ҮОсолд өртсөн ажилтны эмчилгээний зардлыг эмчлэгч эмчийн дүгнэлтийг үндэслэн АО хариуцах ба зардалд сайн дурын үндсэн дээр эмчлүүлсэн зардал орохгүй	8.6	АО бүрэн хариуцаж байгаа. ҮО өртсөн ажилтны үндсэн цалинг бүрэн олгож, энэ хугацаанд Нийгмийн даатгалын листтэй бол листний мөнгийг олгож зөрүү гарвал нэмж олгож байгаа. 2025 онд нийт 5 үйлдвэрлэлийн осол гарсан бөгөөд бүгдийг нь журмын дагуу бүртгэсэн.	100%

VIII Бүлэг-Үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаа

Жил бүрийн 6 сарын 13-ны өдрийн арга хэмжээг зохион байгуулах газар болон ажилтнуудад мэдээлэл хүргэхэд ҮЭХ-д туслах. АО-н төлөөллөөс оролцох	9.1	Тус арга хэмжээг зохион байгуулах газар болон ажилтнуудад мэдээлэл хүргэхэд ҮЭХ-д тусласан. Мөн АО-н төлөөллөөс оролцсон.	100%
ҮЭХ нь АО-н хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр сургалт, хурал, семинарыг з/бх ба АО нь ажилтныг оролцох боломжоор хангана	9.2	Хамтын гэрээ, санамж бичигт заасан болон бусад хуралд оролцох боломжоор хангаж байгаа.	100%
Тэргүүлэгч гишүүд нь ажиллах хуваарьтай өдрүүдэд Нэгдсэн хурал; Санамж бичгийн хурлуудад оролцоход цалинтай чөлөө олгох ба тэргүүлэгч өөрийн удирдлагад урьдчилан мэдэгдэнэ.	9.3	Нэгдсэн хурал; Санамж бичгийн хурлуудад оролцоход цалинтай чөлөө олгож байгаа.	100%
ҮЭХ-ны дарга нь орон тооны сонгуульт ажилтан байх ба Ажил олгогчид ажиллах эсэхийг Компани болон ҮЭХ-ны дүрэм, журам, гэрээний дагуу тогтооно. ҮЭХ-ны даргад энэхүү Хамтын гэрээ бүрэн үйлчилнэ.	9.4	Хэрэгжүүлж байгаа.	100%
Үйлдвэрлэлийн тасралтгүй үйл ажиллагааг хангах ажлын байрны жагсаалтыг Ажил олгогч гаргана.	9.5	Компани жагсаалтыг гаргахаар ажиллаж байна. Харин ҮЭХороодод танилцуулахаасаа өмнө хэрхэн хэрэгжүүлэх вэ гэдэг дээр тодорхой санал гаргахаар ажиллаж байна.	100%
ҮЭХ-г ажлын байрны тохиромжтой газруудад мэдээллийн самбар байрлуулах боломжоор хангана	9.6	Самбар байрлуулах боломжоор хангасан.	100%
ҮЭХ-ны гишүүнийг ҮЭХ-ны үйл ажиллагаанд оролцсоны төлөө ажлаас халах, албан тушаал бууруулж үл болно.	9.7	Ийм тохиолдол гараагүй.	100%
Ажил олгогч нь ҮЭХ-ны тэргүүлэгч гишүүдийг урам зоригийн манлайллын сургалтанд хамруулна.	9.8	Нийт 17 хүн хамрагдсан, 12 сарын 8-9-нд үлдсэн 10 хүнийг хамруулна.	

Жил бүр амжилт гаргасан 5-с доошгүй Ажилтныг туршлага судлах олон улсын бизнес аялалд хамруулна. Ажилтнуудын 50 хувь нь ҮЭХ-ны гишүүн байна.	9.9	Австрали улс – Каррата/Дампиер (2025 оны 8 сар) Нөөц болон Систем - 2, Капитал төсөл - 2, CSS - 5, ҮА нэгтгэсэн төлөвлөлт – 1, Т/Логистик – 1, ГУ төслийн үйлчилгээ - 1, ХН – 1, Механик ЗҮ – 2 Нийт 15 (11 ажилтан нь ҮЭ гишүүн)	100%
ҮЭХ-нд компьютер, принтер, суурин утсыг үнэ төлбөргүй ашиглуулна. ХОСБ хурал, уулзалтуудад ҮЭХ-ны дарга нарын оролцох зохицуулалтыг (Уурхайн талбар руу ирэх, буцах нислэг, байр, уулзалт хурлын өрөө, хоол) Ажил олгогч хариуцна.	9.10	Хэрэгжүүлж байгаа.	100%
Гишүүнчлэлийн татварыг цалингаас нь суутгана. Тус суутгалыг Ажилтны бичгээр өгсөн зөвшөөрлийг үндэслэн хийнэ. Бичгээр зөвшөөрөл өгөөгүй тохиолдолд гишүүний татвар хураах ажлыг ҮЭХ хариуцна. Ажил олгогч нь гишүүдийн цугласан татварыг цалин тавьж олгосноос хойш ажлын 5 өдөрт багтаан ҮЭХ-ны дансанд шилжүүлнэ	9.11	Хэрэгжүүлж байгаа.	100%
Ажил олгогч нь Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний сургалт, сурталчилгааг бүх шатны ажилтнуудад тодорхой, дэлгэрэнгүй хүргэх, үнэлгээний арга зүй, чанар, жигд хүртээмжид хяналт тавих, үнэлгээний аргачлал болон өөрчлөлтийн талаар ҮЭХ болон Ажилтнуудад цаг тухайд нь мэдээлэл хүргэж байна	9.12	1-р улиралд: Ажилтанд зориулсан гүйцэтгэлийн зорилтоо тодорхойлохтой холбоотой видео зааварчилгааг 2025 оны 1 сард ажилтнуудын сувгуудаар хуваалцсан (2031 үзэлттэй)	100%
		2-р улиралд: Оны хагас жилд явцын уулзалтын талаар ажилтнуудад зориулсан зааварчилгаа мэдээллийг ажилтнуудын мэдээлэл хүргэх сувгуудаар хуваалцсан	
		3-р улиралд: Ажилтнуудад зориулсан гүйцэтгэлийн үнэлгээг хэрхэн хийж гүйцэтгэхтэй холбоотой цахим сургалтын агуулга боловсруулагдаж 2025 оны 10-р сард ажилтнуудад хүргэсэн	
		4-р улиралд: Ахлах удирдлагуудад зориулсан 4н удаагийн сургалтыг мөн 2025 оны 10-р сард зохион байгуулсан	
		Үнэлгээний аргачлалд өөрчлөлт ороогүй. Зөвхөн үнэлгээний систем workday рүү шилжсэн.	
Давхар гишүүнчлэлтэй байх эсэхийг ҮЭХ-ны дүрэм, журамд зааснаар тодорхойлно. АО нь ҮЭХ-ны хүсэлтээр гишүүдийн мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу гарган өгч, хамтарч ажиллана.	9.13	ҮЭХороодын хүсэлтийн дагуу өөрсдийнх нь гишүүдийн талаарх мэдээллийг цаг тухай бүрт нь гарган өгч ирсэн.	100%

Х Бүлэг- хамтын гэрээний хэрэгжилт, хяналт тавих, биелэлтийг дүгнэх

Хэлэлцээ хийх, хэрэгжилтийг хянах ажлыг ажлын цагаар хийх ба тэргүүлэгчийн цалинг ажилласнаар тооцох	10.1	Хэрэгжүүлж байгаа	100%
ХГ-г хэрэгжүүлэх, хяналт тавихад холбоотой гэж үзсэн мэдээллийг харилцан солилцоно.	10.2	Хэрэгжүүлж байгаа. Хүсэлт гаргасан тохиолдолд мэдээллийг хүргүүлж байгаа.	100%
ХГнд доорхын дагуу н/өөрчлөлт оруулж болно. Үүнд:	10.3	Одоогоор аль нэг талаас нэмэлт өөрчлөлт оруулах талаар санал гаргаагүй байна.	100%
(1)Хамтын гэрээний хэрэгжилтийн явцыг хянах процессийг талууд ХОСБ-р тохирно.			
(2)ХОСБ-р тохирсны дагуу, 12 сар тутамд хэрэгжилтийг хянах үед нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналыг хэлэлцэж, өөрчлөлт оруулах эсэхийг шийдвэрлэнэ.			
ХГ хугацаа дуусах үед Талуудын аль нэг нь цуцлах, нэмэлт өөрчлөлт оруулах талаар бичгээр мэдэгдээгүй бол анх байгуулсан хугацаагаар сунгасанд тооцно.	10.4	Хугацаа дуусах болоогүй байгаа.	100%
ХГ-ний үүрэг зөрчигдсөн гэж үзвэл аль нэг тал нь Талуудын хурлыг ажлын 5 хоногт зарлан хуралдуулна.	10.5	Ийм тохиолдол гараагүй байна	100%
ХГ байгуулах болон хэрэгжүүлэх явцад үүссэн маргааныг хамтран хэлэлцэж шийдвэрлэнэ. Хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй бол маргааныг Монгол Улсын хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.	10.6	Маргаан гараагүй.	100%
ХГ-г Англи, Монгол хэл дээр үйлдэх ба агуулга, утга тайлбарын зөрүү гарвал Монгол эхийг баримтална.	10.7	Зөрүү гараагүй.	100%
Дүгнэлт			97.60%

